



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/19

Хужирт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд “Багийн төв барих ӨВАХУСЗДТГ/20240201004” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Л.Цэдэв (Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Д.Уранчимэг (Санхүүгийн албаны дарга)

Д.Мөнхбат (Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Б.Жамъянсүрэн (Иргэний төлөөлөл-зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: Б.Бямбасүрэн (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (Л.Цэдэв)-д үүрэг болгосугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу архивын нэгж бүрдүүлэн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Бямбасүрэн)-д даалгасугай.

ДАРГА

Д.БАТБАЯР

622401037

D:Alban bichig;Zahiramj 2024